



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 0/281

Улаанбаатар хот

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 20/21, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 24/05 дугаар тогтоол, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020 оны 20 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хуучнаар “Автобус 3” НӨҮГ-ын барилга байгууламжийг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчилсантай холбоотой дуудлагын худалдааны ялагчид эд хөрөнгийг хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хангах, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Итгэл/-т үүрэг болгосугай

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000703

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны .06. сарын .15. –ний өдрийн ...~~1081~~... дугаар тушаалын хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Дарга	Д.Итгэл	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга
Гишүүд	Б.Адъяа	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн
	М.Буяннэмэх	“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч
	А.Одчимэг	“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын Санхүү, бүртгэлийн хэлтсийн Үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогч
Нарийн бичгийн дарга	Ч.Мөнхбаяр	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн ахлах мэргэжилтэн